



ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН САНАА

ХӨГЖИМ
(Бага боловсрол)
№ 1, 2019

Энэхүү хичээлийн арга зүйн санаа нь ээлжит хичээлийг төлөвлөх, заах багшийн арга зүйг сайжруулах, сурагчдын сурлагын амжилтыг ахиулах, сургууль, багш нар сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Даалгавар: А. Дэвсгэр шугам дээрх эгшгүүдийг нэрлэж бичнэ үү. Нэрлэж бичсэн ноотныхоо уртыг тэмдэглэж бичээрэй. [1]



До До - - - - -


Дөрөвт Хагас - - - - -

Б. Ноотоо хараад бишгүүр хөгжмөөр хөгжимдөөрэй. Хөгжимдөхийн өмнө хэмнэлийг алга ташаарай. [1]

Сурагчдын даалгаврын гүйцэтгэл:

Агуулга/чадвар	Гүйцэтгэлийн хувь
Эгшгүүдийг нэрлэх	27,6%
Эгшгийн уртыг тоо болон үгэн тэмдэглэгээгээр бичих	16,1%
Ноот уншиж хөгжимдөх	10,7%

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлд хийсэн шинжилгээ:



Сургалтын сайжруулсан хөтөлбөрт сурагчдын ноот унших чадварыг дээшлүүлэхийн тулд тодорхой нэг хөгтэй хөгжмийн зэмсгээр сургалт, үйл ажиллагааг явуулахаар тусгасан. Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг харахад эгшгийн уртыг тэмдэглэж нэрлэх чадвар хангалтгүй, ноот бичвэрийг ажиглаад бишгүүр болон пианика хөгжмөөр хөгжимдөх чадвар бусад даалгаврын гүйцэтгэлээс доогуур байна.

Сурагчдын буруу хариултыг шинжилж үзэхэд дэвсгэр 5 шугам дээр ноотны байрлалыг мэдэхгүй байх, зөрүүлж бичих тохиодол их байгаа бол эгшгийн уртыг тэмдэглэхдээ математикийн хичээлийн зүй тогтолоор ихэнх нь бичсэн байна.

Энэ нь зарим сургуулиуд зөвхөн хурууны дугаараар хөгжимдөх үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд эгшгийн тоон тэмдэглэгээтэй андуурах явдал нилээд байгаа нь сурагчдын ноот унших чадварт сөргөөр нөлөөлөх магадлалтай юм. Мөн хөгжмийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, сурагчдын идэвх оролцоо, багшийн заах арга зүй, үйл ажиллагаатай холбоотой байх талтай байна.


ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН САНААНЫ ЖИШЭЭ

Суралцахуйн зорилт: 4.1в.Мажор, минорын ладад хялбар аялгууг бишгүүрээр /пианика/ хөгжимдөж чадахаа харуулах

Даалгаврын жишээ: Ноот бичвэрийг ажиглаад хэмнэлээр тогшоод, хөгжимдөөрэй.



Бүтээлч үйл явцын зураглал:



Даалгаврын зорилго:

- Ноот бичвэрт ажиглалт хийж, аялгууны чиглэл, хөдөлгөөн /өгсөх, уруудах/, уртыг мэдэрч, эгшгийг нэрлээд хөгжимдөх

Танин мэдэхүйн үйл	Арга зүйн санаа
Ажиглах	<p>Даалгаварт өгөгдсөн ноот бичвэрийг ажиглах: Асуулт:</p> <ul style="list-style-type: none"> • Ямар эгшгүүд байна вэ? • Эгшгүүдийн хөдөлгөөнийг ажиглаад, өгсөх уруудах дарааллаар нэрлэж бичнэ үү? Карт ашиглаж болно. <p>Moderato</p>
Гүйцэтгэх	<p>- Хөгжмийн зэмсэг ашиглахгүйгээр хэлний цохилгын дасгалыг хийж гүйцэтгэх.</p> <p>Ноот бичвэр дэх эгшгийн уртыг тодорхойлоод, хэмнэлийн карт ашиглан зөв дараалалд оруулан дасгал хийх.</p> <ul style="list-style-type: none"> • Хөгжмийн зэмсэгт эгшгүүдийн байрлалыг тэмдэглэх <p>Тэмдэглэлийн дагуу ноот бичлэгийг харж хөгжимдөх</p>

<p>Гүйцэтгэлийн үр дүнг нягтлах, үнэлэх</p>	<p>Ноот бичвэрийг хараад хос хосоороо хөгжимдөнө. Хөгжимдөхдөө ширээний найзынхаа зөв хөгжимдөж буйд үнэлгээ өгөх. Үнэлэхдээ дараах шалгуурыг барина.</p> <ul style="list-style-type: none"> - Хөгжмөө зөв барьж, хөгжмийн даруулын нүхийг гүйцэд дарсан байна уу? - Амьсгааг бүрэн дүүрэн авч жигд зөөлөн үлээж байна уу? - Амьсгааг авч, гаргах явцдаа өгөгдсөн хэмнэлээр хэлний цохилгыг хийж гүйцэтгэж байна уу? - Амьсгааны тэмдгийг анхаарч хөгжимдөж байна уу? - Хөгжимдөхдөө хурууны дугаарыг баримталж байна уу?
<p>Дүгнэлт хийх, эргэцүүлэн бодох,</p>	<p>Дараах асуултын дагуу эргэцүүлэн бодож, дүгнэх:</p> <ul style="list-style-type: none"> - Сурагчид аль үйлийг алдаж байна вэ? сурагчдын алдсан үйлийг жагсаан бичнэ. Жагсаан бичсэн үйлээ хамгийн их алдсан давхардалаар эрэмбэлнэ. - Яагаад алдсан гэж бодож байна вэ? хэлэлцүүлэг өрнүүлнэ. <p>Цаашид алдаагүй хэрхэн, зөв хөгжимдөх талаар анги нийтээрээ хэлэлцээд, хөгжимдөх дүрэм зохиогоорой.</p>

Багшид зориулсан нэмэлт зөвлөмж:

- Хүүхэд бүр өөрийн гэсэн хөгжимтэй болохыг сануулж, бусдад дамжуулах нь амьсгалын болон амны хөндийн эрүүл ахуйд нийцэхгүй гэдгийг ойлгуулна.
- Өөрийн гүйцэтгэлийн үр дүнгээ харуулах, бусдын хөгжимдөхийг харж, үнэлэх боломжийг олгох хэрэгтэй.
- Хичээлийг сонирхолтой болгохын тулд хэмнэлийн карт, эгшгийн нэрийг дугуй карт дээр бичээд зөв байрлуулах зэргээр ажиллуулж болно.

Эх сурвалж:

- БСШУСЯ., (2019)., Бага боловсролын хөгжмийн сургалтын хөтөлбөр.Улаанбаатар.www.mier.mn
- Боловсролын хүрээлэн.,(2018).,ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны тайлан. Улаанбаатар
- <https://funmusicco.com/fun-music-company-curriculum/>

Боловсруулсан: Х.Энхжаргал